



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын  
ашиглалтад тавих ерөнхий шаардлага**

**MNS 6877:2020**

Албан хэвлэл

**Стандарт, хэмжил зүйн газар  
Улаанбаатар хот  
2020 он**

## **Өмнөх үг**

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын жинхэнэ гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагуудтай хамтран үндэсний стандарт боловсруулах ажлыг зохион байгуулдаг.

Үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэ стандартыг Энэ стандартыг Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй “Улаанбаатар-Цэвэр агаар” төслийн захиалгаар “Монголын Ногоон хотын хөгжил, судалгааны хүрээлэн” ТББ-аас Монгол Улсын Хот төлөвлөлтийн зөвлөх З.Туяа, Зөвлөх инженер Ю.Доржпагма, Д.Мягмар, ХБНГУ-ын барилгын эрчим хүчний зөвлөх С.Түвшинхүү, Монгол Улсын мэргэшсэн архитектор Б.Сарнай, Л.Батзориг, мэргэшсэн инженер Б.Баттөр, Б.Бат-Эрдэнэ, судалгааны мэргэжилтэн Т.Уранбайгал нар боловсруулсан.

Энэ стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Барилгын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэж зөвшилцсөн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)  
Энхтайваны өргөн чөлөө 46А  
Улаанбаатар 13343, Ш/Х-48

Утас: 263860, 266754,  
Факс: (976-11)458032  
E-mail: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)  
[www.estandard.gov.mn](http://www.estandard.gov.mn)

**©СХЗГ, 2020**

**Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.**

## Агуулга

### Танилцуулга

- 1 Хамрах хүрээ
- 2 Норматив эшлэл
- 3 Нэр томъёо, тодорхойлолт
- 4 Эдэлбэр газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага
- 5 Барилгын эрчим хүчний хэмнэлтэд тавих ерөнхий шаардлага
- 6 Ус хангамж
- 7 Ариутгах татуурга
- 8 Сууцны барилгын дулаан хангамж
- 9 Цахилгаан хангамж
- 10 Гамшиг, галын аюулгүй байдлын шаардлага
- 11 Ном зүй

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.040.93; 93.010

|                                                                               |               |
|-------------------------------------------------------------------------------|---------------|
| Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага | MNS 6877:2020 |
| General Requirements for Usage of Household Purpose Lot                       |               |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн С/46 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр сайжруулсан амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх болон шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд эзэмшүүлэх, өмчлүүлэх газар (цаашид эдэлбэр газар гэх)-т хамаарна.

## 2 Норматив эшлэл

Энэхүү стандартыг боловсруулахад ашигласан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас эш татаж хэрэглэнэ. Үүнд:

MNS 5342:2003, Автомашины зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага

MNS 5611:2006, Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага

MNS 5924:2015, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага

MNS 5216:2016, Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага

MNS 5679:2019, Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага

MNS 5083:2001, Шингэрүүлсэн нефтийн хий – Ахуйн хэрэглээний түлш - Техникийн шаардлага

MNS 5043:2016, 4.2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага

БНБД 21-05-10, Авто зогсоол

БНБД 31-05-05, Нэг айлын сууц

БНБД 31-09-07, Нэг айлын орон сууцны барилгын төлөвлөлт, угсралт

БНБД 31-01-10, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм

БНБД 40-02-16, Ус хангамж гадна сүлжээ ба байгууламж

**MNS 6877:2020**

БНБД 40-01-14, *Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж*

БНБД 40-05-16, *Барилга доторх ус хангамж ба ариутгах татуурга*

БД 81-101-01, *Барилгын ажлын тоо хэмжээ бодох аргачилсан заавар*

### **3 Нэр томьёо, тодорхойлолт**

#### **3.1**

**эдэлбэр газар дахь барилгажуулах талбайн хил хязгаар**

Эдэлбэр газарт барилга байгууламж барихыг зөвшөөрөх талбайн хил хязгаар;

#### **3.2**

**гудамж**

Явган хүн болон бүх төрлийн тээврийн хэрэгсэл зорчих зориулалтын зурвастай, барилга байгууламжаар хязгаарлагдсан нийтийн эзэмшлийн зам, талбай;

#### **3.3**

**барилгажилтын талбай**

“Барилгын ажлын тоо хэмжээ бодох аргачилсан заавар” БД 81-101-01-ийн 2.11-т заасныг;

#### **3.4**

**барилгажилтын талбайн эзлэх хувь**

Эдэлбэр газрын нийт талбайд барилгажуулсан талбайн эзлэх хувь;

#### **3.5**

**хашаа**

Хөдөлгөөн хязгаарлаж, эдэлбэр газрын талбай, орон зайг тусгаарласан байгууламж;

#### **3.6**

**гадна хашлага бүтээц**

Халааж буй орон зайг гадна орчин буюу халаалтгүй хэсгээс тусгаарлах гадна хана, дээвэр шал, гадна цонх, хаалга;

#### **3.7**

**бусад туслах барилга байгууламж**

Мал, амьтны байр, өрхийн аж ахуй эрхлэх барилга байгууламж, саравч, битүү авто зогсоол, агуулах, ариун цэврийн байгууламж, ногооны хүлэмж зэрэг;

#### **3.8**

**гадна тохижилтын ажил**

Барилгын тухай хуулийн 4.1.25-д заасныг;

#### **3.9**

**ил зогсоол**

Гадна хашлага бүтээцгүй авто тээврийн хэрэгслийн зогсоол;

#### **3.10**

**зураг төсөл**

Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасныг;

### **3.11**

#### **орон сууц**

Хүн суурьшин амьдрах зориулалттай барилга;

### **3.12**

#### **барилгын өндөр**

Барилгын босоо хэмжээс буюу газрын түвшнээс дээврийн хамгийн өндөр цэг хүртэлх хэмжээ;

### **3.13**

#### **дулааны гүүр**

барилгын хана, хашлага бүтээцэд зэрэгцэн орсон материалын дулаан дамжуулах шинж чанарын ялгаатай байдал болон тэдгээрийн байрлалаас хамаарч дулаан илүү ихээр алдагдаж байгаа тодорхой хэсгүүд;

### **3.14**

#### **төвлөрсөн бус ус хангамж**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.2-т заасныг;

### **3.15**

#### **төвлөрсөн ус хангамж**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.1-д заасныг;

### **3.16**

#### **ариутгах татуурга**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.3-т заасныг;

### **3.17**

#### **бохир усны цооног**

Бохир усыг хуримтлуулж, түүнийг зөвөрөөр зайлуулдаг ашиглалт, үйлчилгээ хийх шаардлага хангасан хийц бүхий байгууламж;

### **3.18**

#### **нэвчилтгүй жорлон, угаадасны нүх**

“Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924:2015 стандартын 4.4-т заасныг;

## **4 Эдэлбэр газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага**

### **4.1 Эдэлбэр газарт явуулах үйл ажиллагаа**

Эдэлбэр газрыг хуулиар зөвшөөрсөн зориулалтаар ашиглана. Үндэсний аюулгүй байдалд харшлах үйл ажиллагаа явуулах, зориулалтын бус (тэсэрч дэлбэрэх болон химийн бодис ашиглах, хадгалах, ус, хөрс, агаарын бохирдол үүсгэх үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах гэх мэт)-аар ашиглахыг зөвшөөрөхгүй.

## **4.2 Эдэлбэр газар дахь барилгажуулах талбайн хил хязгаар**

Эдэлбэр газар дахь барилгажуулах талбайн хил хязгаарыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- Эдэлбэр газрын гол орц талаас 5 метрээс багагүй зайтай, бусад хажуу талуудаас 3 метрээс багагүй зайтай байхаар тооцно.
- Хэрэв эдэлбэр газар нь хоёр талаараа гудамжтай бол эдэлбэр газрын гудамж талуудаас 5 метрээс багагүй зайтай байхаар тооцно.

## **4.3 Эдэлбэр газрын барилгажилтын талбай**

**4.3.1** Барилгажилтын талбайн хэмжээг тогтоохдоо тухайн газрыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баримтална.

**4.3.2** Хэрэв хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодорхой тусгаагүй тохиолдолд барилгажилтын талбайн хэмжээг эдэлбэр газрын хэмжээнээс нь хамааруулан нийт талбайн (30-40) хувь байхаар тогтооно.

### **1-р хүснэгт - Эдэлбэр газрын барилгажилтын талбайн эзлэх хувь**

| Д/д | Эдэлбэр газрын хэмжээ (м <sup>2</sup> ) | Барилгажилтын талбайн эзлэх хувь (%) |
|-----|-----------------------------------------|--------------------------------------|
| 1   | 700 хүртэл                              | 40 хүртэл                            |
| 2   | 701-ээс дээш                            | 30 хүртэл                            |

## **4.4 Талбайн бэлтгэл ажил**

**4.4.1** Газрын гадаргын түвшин нь 10 метр тутамд 1,4 метрээс их зөрүүтэй (8°-аас их налуу) байгаа тохиолдолд:

- Барилга барих талбайг бэлтгэхдээ хөрсний нуралт, гулсалтаас хамгаалсан бэхэлгээг хийнэ.
- Эргэн тойрны гудамжинд үерийн ус зайлуулах байгууламж байхгүй бол эдэлбэр газартаа үер, хур ба уруйн усыг залах, эрчийг сааруулах суваг, ус хураах талбайг байгуулна.

**4.4.2** Барилгын давхрын тооноос хамаарахгүйгээр борооны ус цуглуулах суваг ба хоолойг тоноглож, усыг цуглуулах савтай байна.

## **4.5 Хашаа**

**4.5.1** Хашааг кадастрын зургийн дагуу дараах нөхцөлийг хангаж барина. Үүнд:

- явган зорчигч болон авто замын хөдөлгөөнд саад учруулахгүй;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих зам, хөдөлгөөний харагдах орчныг хязгаарлахгүй;
- авто замын уулзварын үзэгдэх орчныг хязгаарлахгүй;

**4.5.2** тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлсэн байна.

**4.5.3** Хашаа нь 0,8-2 метрийн өндөртэй байна.

**4.5.4** Хашаанд барилгын материалын оронд мод, сөөг ашиглаж болно.

**4.5.5** Хашаа нь сараалжин хийцтэй байж болно.

**4.5.6** Гудамжны өргөн 6 метрээс бага тохиолдолд хашааны буланг 3х3 метр хэмжээтэйгээр 45°-аар дотогш татаж үзэгдэх орчныг чөлөөлнө.

**4.5.7** Гал дамжих эрсдэлийг бууруулах зорилгоор хашааны суурийг газрын түвшнээс дээш 30 см гарган бетоноор хийж болно.

**4.5.8** Гадаргын урсцыг тогтоохгүй байхаар газрын гадаргын нам хэсэг дэх хашааны бетон сууринд ус зайлуулах нүх гарган төмөр сараалжаар тоноглож болно.

**4.5.9** Хашааны бүх хаалгыг дотогшоо онгойдог эсхүл гүйдэг байхаар хийнэ.

**4.5.10** Эдэлбэр газрын хашааны дугаарыг “Гудамж, зам, талбай, үл хөдлөх үл хөрөнгийг хаягжуулах журам”-д заасны дагуу хашааны хаалгыг голлуулан дээд талд нь байрлуулна.

#### **4.6 Эдэлбэр газар дахь орон сууцны барилга ба бусад туслах барилга байгууламжуудын байршил болон хоорондын зай**

**4.6.1** Эдэлбэр газарт дараах нөхцөлийг харгалзан барилга байгууламжийг байршуулбал зохино. Үүнд:

- Сууцны барилгыг байгалийн гэрэлтүүлгийг хамгийн ихээр ашиглахаар байршуулна.
- Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор эдэлбэр газар дахь барилга байгууламж хоорондын хамгийн бага зайг 2 дугаар хүснэгтэд заасны дагуу тооцно.
- Зэргэлдээ хашааны барилга байгууламж хоорондын зай хэмжээг тогтоохдоо эдэлбэр газрын кадастрын хил болох хашаанаас хоёр талдаа 2 дугаар хүснэгтэд заасан хэмжээг ижил тэнцүү хуваасан хэмжээгээр тооцно.

#### **2-р хүснэгт - Барилга байгууламжийн хоорондын зай**

| Д/д | Барилгын гал тэсвэршилтийн зэрэг<br>(Барилгын материал)                                         | Барилга байгууламжийн хоорондын<br>зай (метр) |     |    |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------|-----|----|
|     |                                                                                                 | I, II                                         | III | IV |
| 1   | I, II<br>(барилгын гадна хашлага бүтээц<br>нь шатдаггүй материалаар<br>хийгдсэн)                | 6                                             | 8   | 10 |
| 2   | III<br>(барилгын гадна хашлага бүтээц<br>нь шатдаг болон шатдаггүй<br>материалаар хийгдсэн бол) | 8                                             | 8   | 10 |
| 3   | IV<br>(барилгын гадна хашлага бүтээц<br>нь шатдаг материалаар хийгдсэн<br>бол)                  | 10                                            | 10  | 15 |

**4.6.2** Эдэлбэр газар дахь барилгажуулах талбайн хил хязгаар дотор түр сууц болон гэр барьж болно.

#### **4.7 Гадна тохижилт**

**4.7.1** Эдэлбэр газарт гадна тохижилтын талбайн эзлэх хувийг 3-р хүснэгтийн дагуу тооцно.



**3-р хүснэгт - Тохижилтын эзлэх хувь**

| Д/д | Эдэлбэр газрын хэмжээ<br>(м <sup>2</sup> ) | Гадна тохижилт<br>(%) | Үүнээс ногоон<br>байгууламж (%) |
|-----|--------------------------------------------|-----------------------|---------------------------------|
| 1   | 700 хүртэл                                 | 60-аас багагүй        | 30-аас багагүй                  |
| 2   | 701-ээс дээш                               | 70-аас багагүй        |                                 |

**4.7.2** Эдэлбэр газарт гэрэлтүүлэг төлөвлөнө.

**4.8 Автомашины зогсоол**

**4.8.1** Автомашины зогсоолыг барилгажуулах талбайн хил хязгаар дотор төлөвлөнө.

**4.8.2** Автомашины зогсоолыг “Авто зогсоол” БНБД 21-05-10, “Автомашины зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342:2003 стандартыг үндэслэн төлөвлөнө.

**4.8.3** Эдэлбэр газарт нэгээс багагүй ил зогсоол төлөвлөнө.

**4.8.4** Ил зогсоолын талбайд ус нэвчүүлэх нүхтэй хавтан ашиглана.

**4.9 Барилга, байгууламжийн зураг төсөл**

**4.9.1** Барилга байгууламжийг барилгын норм, дүрмийн дагуу боловсруулсан зураг төслөөр барина.

**4.9.2** Орон сууцны барилга нь “Нэг айлын сууц” БНБД 31-05-05, “Нэг айлын орон сууцны барилгын төлөвлөлт, угсралт” БНБД 31-09-07, “Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт” БД 30-101-05, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм” БНБД 31-01-10, “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04, “Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага” MNS 5611:2006 стандарт, норм дүрмийн шаардлагыг хангасан байна.

**4.9.3** Холбогдох байгууллагаар баталгаажсан нэг маягийн барилгын зургийг ашиглаж болно. Хэрэв тухайн эдэлбэр газрын хөрсний шинж чанар болон газар хөдлөлтийн балл нь зураг төслийн тооцооны үзүүлэлтээс өөр бол зохих өөрчлөлтийг оруулсан зураг төслөөр барина.

**4.10 Барилгын зөвшөөрөгдөх өндрийн дээд хэмжээ**

**4.10.1** Барилгын зөвшөөрөгдөх өндрийн дээд хэмжээг тогтоохдоо тухайн газрыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баримтална.

**4.10.2** Хэрэв хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодорхой тусгаагүй тохиолдолд өндрийн дээд хэмжээг дараах байдлаар тогтооно.

- Сууцны барилгын зөвшөөрөгдөх дээд өндөр нь газрын түвшнээс дээш 10 метрээс ихгүй байна.

- Хашаан доторх бусад туслах барилга байгууламжийн зөвшөөрөгдөх дээд өндөр нь газрын түвшнээс дээш 4,8 метрээс хэтрэхгүй байна.

**4.11 Хог хаягдлын ангилал, цуглуулалт**

**4.11.1** Ахуйн хог хаягдлын анхан шатны ангиллыг хашаандаа хийх бөгөөд дахивар хаягдал, хүнсний хаягдал, үнсний болон бусад хог хаягдал гэсэн ангиллаар битүү сав, чингэлэгт түр хадгалж ачуулна.

**4.11.2** Хогийн сав, чингэлэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хог хаягдлын ангилал бүрээр тус тусын таних тэмдэглэгээ бүхий зориулалтын савтай байна;
- өргөж ачихад тохиромжтой;
- галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- шүүрэл ялгарахаас сэргийлсэн;
- битүү, тагтай савтай байна.

**4.11.3** Эдэлбэр газар дахь хогийн сав, чингэлгийн байршил

- Хогийн сав, чингэлгийн байршлыг салхины чиглэлийг харгалзан тогтооно.
- Хогийн сав, чингэлэг задгай, сүүдэртэй газар байх нь тохиромжтой ба хажуугийн барилгын цонх, агааржуулалтын төхөөрөмжөөс зайдуу байршуулна.

**5 Барилгын эрчим хүчний хэмнэлтэд тавих ерөнхий шаардлага****5.1 Гадна хашлага бүтээцийн дулаан тусгаарлалт**

Барилга, орон сууцны халааж буй хэсгийг гадна агаар, газрын хөрс буюу нам температур бүхий орчноос тусгаарлах хашлага бүтээцийн дулаан тусгаарлалт нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- Гадна хананы дулаан тусгаарлалт: Гадна ханын даацын цуллаг хийц бүтээцийн зузаанаас үл хамааран дулаалгын материалын зузаан нь 15 см-ээс багагүй байна.
- Дээвэр, дээд давхрын хучилтын дулаан тусгаарлалт: Барилгын дээвэр, дээд давхрын хучилтад хэрэглэх дулаалгын материалын зузаан 20 см-ээс багагүй байна.
- Шалны дулаан тусгаарлалт: Барилгын шал нь газрын хөрсөнд суух тохиолдолд түүний дулаалгын материалын зузаан 10 см-ээс багагүй байх ба хөндий шалны хувьд гадна ханын дулаалгын зузаантай тэнцүү буюу 15 см-ээс багагүй байна.
- Гадна цонхны дулаан тусгаарлалт: Гадна цонхны шиллэгээ нь 3 давхар шилэн багцтай, рам нь 5 хөндийтэй буюу түүнээс дээш үзүүлэлттэй байна.
- Гадна хаалганы дулаан тусгаарлалт: Барилгын гадна хаалганы рам болон самбар нь дулаалгатай байх ба битүүмжлэлийг хангахуйц уян жийргээр тоноглогдсон байна.
- Халаалтгүй өрөө болон айл хоорондын хамар ханын дулаан тусгаарлалт: Барилга, орон сууцны халаалтгүй хэсэг болон айл хоорондын тусгаарлах хана нь даацын цуллаг хийц бүтээцийн зузаанаас үл хамааран дулаалгын материалын зузаан нь 8 см-ээс багагүй байх ба айл хоорондын тусгаарлах хананд шатдаггүй материал ашиглана.

**5.2 Барилгын хашлага бүтээцийн дулааны гүүр**

Барилгын дулааны хэрэглээнд дулааны гүүрийн үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хашиж буй гадаргуугийн талбайн хэмжээг халааж буй эзлэхүүний хэмжээнд харьцуулсан харьцааг бага байхаар төлөвлөнө.
- Барилгын гадна хашлага бүтээцэд аль болох цөөн төрлийн материал зэрэгцүүлэн хэрэглэнэ.

- Барилгын гадна хашлага бүтээцийн даацын болон дулаалгын үе давхаргын хоорондын холболтод дулаан дамжуулалт өндөр (бетон, төмөр бетон, металл гэх мэт) материал хэрэглэхээс татгалзана.
- Даацын болон өнгөлгөөний үеүдийг холбосон бэхэлгээний дулаалгын үеийг нэвтрэх хэсгийн голчийн хэмжээ бага байна.
- Зайлшгүй ил гарч байгаа дулааны гүүрийг гадна талаас нь бүрж хамгаална.

### 5.3 Барилгын битүүмжлэл

**5.3.1** Шинээр барьж буй болон шинэчлэн засварлаж байгаа барилга, орон сууцны дулаан тусгаарлах хашлага бүтээц болон түүний шов заадлын битүүмжлэлийг урт хугацааны туршид гадна талаасаа салхи үл нэвтрүүлэх, дотор талаасаа гадна хийц бүтээцэд уур нэвчихээргүй хүлээн зөвшөөрөгдсөн арга технологийн дагуу гүйцэтгэнэ.

**5.3.2** Орон сууцны зориулалттай барилгын өрөө тасалгааны агаар сэлгэлтийн тоо нь агааржуулалтын хэлбэрээс хамааран ердийн агаар сэлгэлттэй бол цагт 4-өөс ихгүй, механик агаар сэлгэлттэй бол 2-оос ихгүй байна.

### 5.4 Орон сууцны барилгын дулааны жилийн хэрэгцээ

Орон сууцны нэгж талбай буюу эзлэхүүнд хамаарах барилгын халаалтын дулааны эрчим хүчний зөвшөөрөгдөх дээд хэмжээг 4, 5 дугаар хүснэгтийн дагуу тооцно.

4-р хүснэгт - **Орон сууцны барилгын нэгж эзлэхүүнд харгалзах халаалтын дулааны эрчим хүчний зөвшөөрөгдөх дээд хэмжээ [кВтц/ (м<sup>3</sup> жил)]**

| Барилгын талбай, м <sup>2</sup> | Давхрын тоо |    |    |
|---------------------------------|-------------|----|----|
|                                 | 1           | 2  | 3  |
| 50                              | 97          | -  | -  |
| 100                             | 87          | 94 | -  |
| 150                             | 76          | 83 | 90 |
| 250                             | 70          | 73 | 76 |
| 400                             | 62          | 62 | 66 |

5-р хүснэгт - **Орон сууцны барилгын нэгж талбайд харгалзах халаалтын дулааны эрчим хүчний зөвшөөрөгдөх дээд хэмжээ [кВтц/ (м<sup>2</sup> жил)]**

| Барилгын талбай, м <sup>2</sup> | Давхрын тоо |     |     |
|---------------------------------|-------------|-----|-----|
|                                 | 1           | 2   | 3   |
| 50                              | 304         | -   | -   |
| 100                             | 271         | 293 | -   |
| 150                             | 239         | 260 | 282 |
| 250                             | 217         | 228 | 239 |
| 400                             | 195         | 195 | 206 |

### 5.5 Барилгын хашлага бүтээц дэх цонх ба түүний хэмжээ

**5.5.1** Хойшоо харсан цонхноос аль болох татгалзах, хэрэв зайлшгүй шаардлагатай тохиолдолд байгалийн гэрэл нэвтрүүлэх зорилгоор цонх төлөвлөж, хэмжээг хязгаарлана.

**5.5.2** Орон сууцны барилгад хэрэглэж буй цонх, шилэн хаалга, гэгээвч зэрэг тунгалаг хашлага бүтээцийн нийт талбайн хэмжээ тухайн гадна ханын нийт талбайн 18 хувиас ихгүй байна. Цонх ба тунгалаг хашлага бүтээцийн нийт хашлага бүтээцэд эзлэх хувь хэмжээг дараах томъёогоор тооцно.

$$F = S_{ц} / (S_{ц} + S_{гх}) * 100\%$$

Энд:  $S_{ц}$  цонхны талбай

$S_{гх}$  гадна ханын талбай

$F$  нийт ханын талбайн хэмжээг цонхны талбайн хэмжээнд харьцуулсан харьцаа

**5.5.3** Цонх болон шилэн ханын хэсэгт шөнийн цагаар хаах дулаан тусгаарлалт сайтай хаалт төлөвлөж болно.

## **5.6 Хуучин барилгын дулааны үр ашиг**

Хуучин барилгад хэрэгжүүлж буй дулаан алдагдлыг бууруулах дулаалгын арга хэмжээний үр ашгийг тухайн барилгын нэгж талбай буюу эзлэхүүнд харгалзах халаалтын дулааны хэрэгцээ ба хэрэглээний бууралтаар тооцно.

## **5.7 Хуучин барилгын дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээ**

Хуучин барилгын гадна хашлага бүтээцийн дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх тохиолдолд энэхүү стандартын 5.1-д заасан шаардлага тус бүрийг хангана.

## **5.8 Дулаалгын материалд тавих нэмэлт шаардлага**

**5.8.1** Бетон, тоосго зэрэг эрдэслэг гарлын цуллаг материал бүхий хашлага бүтээцэд хөөсөнцрийн төрлийн материал ашиглаж болох ба энэ нь гал дэмждэггүй буюу галд тэсвэртэй материал байна.

**5.8.2** Модон буюу шатдаг материал ашигласан хийцтэй хашлага бүтээцэд эрдэс хөвөн, чулуун хөвөн зэрэг сийрэг бүтэцтэй, галд тэсвэртэй материал хэрэглэнэ.

**5.8.3** Дотор талдаа агааржуулалтын үетэй төрөл бүрийн өнгөлгөө бүхий хана, хашлага бүтээцийн дулаалгад гал түймрийн үед унтраах боломж хязгаарлагддаг тул зайлшгүй шатдаггүй материал хэрэглэнэ.

## **6 Ус хангамж**

### **6.1 Төвлөрсөн ус хангамжийн шугамаас хангагдах**

**6.1.1** Ус хангамжийн шугам сүлжээнд унд ахуйн ус дамжуулах зориулалтын яндан хоолойг “Ус хангамж гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-02-16-д нийцүүлэн угсарна.

**6.1.2** “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 17.6-д заасны дагуу цэвэр усны шугамд хамгаалалтын зурвас тогтооно.

**6.1.3** Ус хангамжийн шугамыг нүхэн жорлонгоос 10 метрээс ойр зайд угсрахыг хориглох ба нэвчилтээс хамгаалж футляр (гэр) хоолойд сүвлэнэ.

### **6.2 Ус түгээх байрнаас усаа зөөвөрлөж хэрэглэх**

**6.2.1** Хэрэглэгч нь ус түгээх байрнаас 500 метрээс бага зайд байрласан байвал зохино.

**6.2.2** Усаа зөөх болон хадгалах хуванцар сав нь Хэрэглэхэд аюулгүй “1”, “5” тэмдэглэгээ бүхий кодтой, эрүүл мэндэд учруулах хор нөлөөлөл багатай “2”, “4” тэмдэглэгээ бүхий кодтой байна. Мөн зэвэрдэггүй ган савыг ашиглаж болно.

**6.2.3** “3”, “6”, “7” тэмдэглэгээ бүхий кодтой хуванцар савыг ашиглахыг хориглоно.

### **6.3 Машинаар тээвэрлэн түгээх усыг авч ашиглах**

Ус авахад хялбар, усны машин орж гарах талбайтай байх нөхцөлийг хангах ба ус зөөх болон хадгалах сав нь 6.2.2-т заасан шаардлагад нийцсэн байна.

### **6.4 Өөрийн гүний худгаас хангагдах**

**6.4.1** Гүний худаг гаргахдаа “Усны тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийг мөрдөнө.

**6.4.2** “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 17.4.1-д заасан шаардлагыг хангасан гүний худгийг усны эх үүсвэр болгон ашиглаж болно.

**6.4.3** Унд ахуйн зориулалтаар гүний худгийн усыг ашиглах нөхцөлд эрүүл ахуй, хамгаалалтын бүсийг худгийн эргэн тойронд тогтоож бохирдлоос хамгаална. Эрүүл ахуй, хамгаалалтын бүсийн болон ундны усны чанарын шаардлага хангаагүй нөхцөлд гүний худгийн усыг ундны зориулалтаар бус ахуйн зориулалтаар ашиглахыг зөвшөөрөх ба бусдад түгээх, борлуулахыг хориглоно.

**6.4.4** Холбогдох хууль болон барилгын норм, дүрэмд зааснаар цэвэр усны шугамын дагуу засвар үйлчилгээ хийх зурвастай байна.

## **7 Ариутгах татуурга**

### **7.1 Төвлөрсөн болон хэсэгчилсэн бохир усны шугам сүлжээнд холбогдох**

**7.1.1** Бохир усыг зайлуулахдаа “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-01-14-ийн 6.2, 6.3 зүйлийн заалтуудын дагуу төлөвлөж угсралтыг хийх ба хэрэглэгчид харьяалагдах үзлэгийн худаг нь эдэлбэр газарт байрласан байна.

**7.1.2** Нийтийн эзэмшил газраар дайрч өнгөрөх бохир усны шугамын дагууд барилгажуулах тохиолдолд “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 17.14 заалтын дагуу засвар үйлчилгээ хийх зурвастай байна.

### **7.2 Бохир усны цооног**

**7.2.1** Эдэлбэр газар нь гэр хороолол дунд байрласан, мөн тухайн газар нь цэвдэг хөрстэй, хөрсний устай (хөрсний усны түвшин 2 метрээс дээш) бол бохир усны цооногийг төлөвлөнө. Бохир усны цооногийг цэвэр усны эх үүсвэр, гол горхиноос 50 метрээс багагүй зайд, гэр, сууцны барилгаас 10 метрээс багагүй зайд газрын хэвгийн доод талд салхины ноёлох чиглэлийг харгалзан байрлуулна.

**7.2.2** Нүхэн жорлон, угаадасны нүхийг “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924:2015 стандартын дагуу төлөвлөнө. Гүн нь 2-оос 3 метр байна. Хашаанаас дотогш 2,5 метрээс багагүй зайд байрлуулна.

**7.2.3** Цэвэрлэсэн бохир усыг зайлуулах болон шүүрүүлэх хангалттай талбайтай нөхцөлд бие даасан бага оврын цэвэрлэх байгууламжийг эдэлбэр газарт ашиглаж болно.

- Септикийг орон сууцнаас 5 метрээс багагүй зайд байрлуулах ба септикээс гарах усыг шүүрүүлэх худаг болон талбайд нэмэлт цэвэрлэгээ хийж бохир усыг бүрэн цэвэрлэнэ.

- Бохир усыг цэвэрлэх боломжтой ба хөрсний төрөл, тухайн эдэлбэр газрын талбай, эргэн тойрон айл байгаа эсэхээс хамаарч шүүрүүлэх худгийг сонгох ба орон сууцнаас 8 метрээс багагүй зайд, бусад хэрэглэгчдээс 100 метрээс багагүй зайд байрлуулна.

## **8 Сууцны барилгын дулаан хангамж**

Шинээр баригдах болон шинэчлэн засварлаж буй хувийн орон сууцанд мэргэжлийн байгууллагаар халаалтын иж бүрэн зураг төсөл хийлгэж, зургийн дагуу халаалтын эх үүсвэрийг сонгож, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

### **8.1 Халаалтын эх үүсвэр**

#### **8.1.1 Хатуу түлш**

- Хатуу түлшний зуух ашиглах бол “Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5216:2016 стандартад нийцсэн байх ба түлшний нөөцийн битүү агуулах, савтай байна.
- Хатуу түлшний зуух нь сайжруулсан буюу утаагаа эргүүлэн шатаах замаар агаарт хаягдах тоосонцрын хэмжээг бууруулах хийц, шийдэлтэй байна.
- Хатуу түлшний зуухны ашигт үйлийн коэффициент 70 хувиас багагүй байна.
- Утааны янданг нарийн ширхэгт тоосонцор буюу тортог барих төхөөрөмжөөр тоноглоно.
- Шаталтаас ялгарах үнсийг гал түймрээс хамгаалах шаардлагад нийцсэн зориулалтын битүү саванд агуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хэрэглэж буй түлш нь “Сайжруулсан хатуу түлш. Техникийн шаардлага” MNS 5679:2019 стандартад нийцсэн байна.

#### **8.1.2 Цахилгаан халаалт**

- Халаалтад цахилгаан эрчим хүчийг ашиглах тохиолдолд холбогдох байгууллагаас техникийн нөхцөл авна.
- Техникийн нөхцөлөөр зөвшөөрсөн хэмжээнээс илүү чадал бүхий халаах хэрэгсэл суурилуулах, ашиглахыг хориглоно.
- Цахилгаан халаалтын эх үүсвэр ашиглах тохиолдолд хэмжих хэрэгсэл буюу цахилгааны тоолуур, автоматаар асаах, унтраах, тохируулах төхөөрөмжөөр тоноглоно.
- Аюулгүйн тоноглол хэмжих, хянах, хамгаалах хэрэгслүүдээр зургийн дагуу иж бүрэн тоноглоно.

**8.1.3 Төвийн халаалтын систем**

- Төвлөрсөн эх үүсвэрээс нэгдсэн халаалтын системээр түгээдэг дулааны эрчим хүчний эх үүсвэрт холбогдох тохиолдолд тухайн ханган нийлүүлэгчээс техникийн нөхцөл авч холболт хийлгэнэ.
- Хэрэглэгчийн салбар шугамын эхлэл дээр хэмжих хэрэгсэл буюу дулааны тоолуур суурилуулж хэрэглээгээ хянах, хэмжих боломжийг бүрдүүлнэ.
- Хэмжих хэрэгслийн дараах холболтын болон түгээлтийн шугамуудын дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг 6 дугаар хүснэгтэд заасан доод шаардлагыг хангана.

**8.1.4 Хийн түлш**

- Ахуйн буюу халаалтын түлшний зориулалтаар хий ашиглах тохиолдолд хий нь байгалийн хийн хувьд ГОСТ 5542-87 “Газы горючие природные для промышленного и коммунально-бытового назначения. Технические условия”, шингэрүүлсэн нүүрс-устөрөгчийн хийн хувьд “Шингэрүүлсэн нефтийн хий – Ахуйн хэрэглээний түлш - Техникийн шаардлага” MNS 5083:2001 стандартын шаардлагыг хангасан байх ёстой. Түүнээс гадна шугам хоолой, тэдгээрийн аюулгүйн тоноглолыг барилгын норм, дүрэмд заасны дагуу мэргэжлийн байгууллагаар зураг төсөл хийлгэж, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн шалган баталгаажуулж ашиглана.

**8.2 Халаалт, халаалтын систем**

**8.2.1 Ханан пийшинтэй энгийн зуух**

- Зуухны хүчин чадлыг барилгын хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн хүнээр тооцоо хийлгэж сонгоно.
- Зуухнаас гарах утааны температурыг хэт хөрж тунадас үүсэхээс хамгаалж ханан пийшингийн хэмжээг зөв сонгох, мөн дээвэр буюу халааж буй хэсгээс дээш гарах яндангийн хэсгийг шатдаггүй материалаар дулаална.
- Яндангийн өндөр болон голч нь тухайн зуухны төрөл, хүчин чадлаас хамаарах тул мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч сонголт хийнэ.
- Шаталтад шаардлагатай агаарыг хангах үүднээс зуух байрлах өрөөнд зориулалтын нүх нээлхий эсвэл зориулалтын суваг хоолой төлөвлөнө.
- Зуухны хүүхээгний голчоос яндангийн орой хүртэлх хэмжээ 4 метрээс багагүй байна.
- Яндан нь дээврийн оройн хэсэгт ойр байрлах тохиолдолд дээврийн оройгоос 40 см–ээс багагүй байна
- Бусад байрлалд дээврийн гадаргууд эгц буух хэмжээ нь 100 см–ээс багагүй хэмжээгээр дээш гарсан байна
- Зуух, ханан пийшингийн хоорондын холболтын битүүмжлэлийг сайтар хангана.

**8.2.2 Нам даралтын буюу бага чадлын халаалтын зуух**

- Нам даралтын буюу бага чадлын халаалтын зуух ашиглах тохиолдолд “4.2 МВт хүртэл чадалтай ус халаах зуух. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5043:2016 стандартад нийцсэн зуух хэрэглэнэ.
- Нэг айлын орон сууцанд усан халаалтын систем суурилуулах тохиолдолд мэргэжлийн байгууллагаар зураг төсөл хийлгэж, С мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- Хатуу түлшний зуухаар халааж буй халаалтын системийн үр ашгийг нэмэгдүүлж, алдагдлыг бууруулах зорилгоор завсрын эзлэхүүний нөөцлүүрийг суурилуулна.
- Цахилгаан эрчим хүчээр халааж буй халаалтын системд оргил ачааллыг бууруулах мөн цахилгаан эрчим хүчний тарифын ялгааг үр дүнтэй ашиглах зорилгоор завсрын эзлэхүүний нөөцлүүрийг суурилуулна.
- Халаалтын эх үүсвэрийн удирдлага нь хувьсах боломжтой бол өрөө тасалгааны халаах хэрэгсэлд автомат тохируулга суурилуулна.
- Халаалтын системийн эргэлтийн насос нь хувьсах зарцуулалт бүхий хамгийн багадаа 3 шатлалтай тавилтай байна.
- Халаалтын тогоо, халаалтын эх үүсвэрээс хэрэглээний халуун ус бэлтгэх тохиолдолд халуун усны богино эргэлтийн насос нь хугацааны хамаарал бүхий асаах, унтраах автомат удирдлагатай байна.
- Шинээр суурилуулж буй болон шинэчилж буй халаалтын систем, хэрэглээний халуун усны системийн түгээлтийн шугам хоолойн дулааны алдагдлыг бууруулах зорилгоор дараах хүснэгтэд заасан зузаанаар дулаална.

**6-р хүснэгт - Шугам хоолойн дулаалгад тавих доод шаардлага**

| Д/д | Шугам хоолой тоноглолын төрөл                                                                                                                    | Дулаалгын материалын дулаан дамжуулалт 0.035 Вт/м*К байх үед дулаалгын зузааны доод хэмжээ (мм) |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Ф22 хүртэл дотор голчтой шугам хоолой, хаалт арматур                                                                                             | 20                                                                                              |
| 2   | Ф22-Ф35 хүртэл дотор голчтой шугам хоолой, хаалт арматур                                                                                         | 30                                                                                              |
| 3   | Ф35-Ф100 хүртэл дотор голчтой шугам хоолой, хаалт арматур                                                                                        | Дотор голчтой нь тэнцүү                                                                         |
| 4   | Ф100-ээс дээш дотор голчтой шугам хоолой, хаалт арматур                                                                                          | 100                                                                                             |
| 5   | 1-4-д заасан шугам хоолойн дулаалгын зузааныг хана, хучилтаар нэвтрэх хэсэг, бусад шугам хоолойтой зөрөх уулзвар зангилаа хэсэгт бууруулж болно. | Шаардлагыг ½ -р бууруулж болно.                                                                 |
| 6   | Шалны бүтцэд сууж буй шугам хоолойг                                                                                                              | 6                                                                                               |
| 7   | Хүйтэн ус болон хөргөлтийн шугам хоолой, хаалт арматур                                                                                           | 6                                                                                               |

**8.3 Төрөл бүрийн бие даасан нөөцлүүргүй цахилгаанаар халаагч**

**8.3.1** Бие даасан цахилгаан халаах хэрэгслүүдийн нийлбэр чадал техникийн нөхцөлд заасан хэмжээнээс давахыг хориглоно.



**8.3.2** Бие даасан цахилгаан халаах хэрэгсэл тус бүр температурын мэдрэгч бүхий автомат тохируулагчтай байна.

**8.3.3** Хэт халаалтын үеийн автомат хамгаалалттай байна.

**8.3.4** Хөмөрч унахаас хамгаалсан хамгаалалт бүхий тоноглол шийдэлтэй байна.

**8.3.5** Шалны цахилгаан халаалт хэрэглэх тохиолдолд эрүүл ахуйн үүднээс шалны гадаргуугийн температур  $29^{\circ}\text{C}$  -ээс давсан байхыг хориглоно.

#### **8.4 Төрөл бүрийн бие даасан нөөцлүүртэй цахилгаан халаагч**

**8.4.1** Шөнийн ялгаатай тариф ашиглах дулааны нөөцлүүр бүхий цахилгаан халаагуур суурилуулах ба халаагуурын чадал 4 кВт-с их бол холбогдох мэргэжлийн газраас техникийн нөхцөл шинээр авна.

**8.4.2** Бие даасан цахилгаан халаах хэрэгсэл тус бүрийн нийлбэр чадал техникийн нөхцөлд заасан хэмжээнээс давсан байхыг хориглоно.

**8.4.3** Бие даасан цахилгаан халаах хэрэгсэл тус бүр температурын мэдрэгч бүхий автомат тохируулагчтай байна.

**8.4.4** Хэт халаалтын үеийн автомат хамгаалалттай байна.

**8.4.5** Дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур нь тарифын болон тарифын бус нөхцөлд шууд ашиглаж болохоор байх ёстой.

**8.4.6** Дулаан хуримтлуурт цахилгаан халаагуурын гадна гадаргуугийн температур нь тасалгааны агаарын температурын зөвшөөрөгдөх утгаас  $300^{\circ}\text{C}$ -ээс ихгүй байх ёстой.

**8.4.7** Хөмөрч унахаас хамгаалсан хамгаалалт бүхий тоноглол шийдэлтэй байх ёстой.

**8.4.8** Эрүүл ахуйн үүднээс асбест агуулаагүй байх шаардлагатай.

#### **9 Цахилгаан хангамж**

**9.1** Нэг айлын орон сууцыг цахилгааны дэд өртөөнөөс 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабел шугамаар тэжээхээр төлөвлөнө.

**9.2** Цахилгаан эрчим хүчний тоолуур бүхий оролтын самбарыг барилгын гадна эсхүл дотор төлөвлөж, газардуулах шаардлагатай.

**9.3** Барилга байгууламжийг орчны нөхцөлөөс хамааруулан аянга хамгаалалтыг хийж өгөх шаардлагатай.

**9.4** Эдэлбэр газрын төлөвлөлттэй уялдуулан эрчим хүчний хэмнэлттэй, гэрэлтэлтээс хамаарч ажиллах автомат удирдлагатай гадна гэрэлтүүлгийг төлөвлөнө.

**9.5** Нэг айлын орон сууцны цахилгаан хангамжид төвлөрсөн эх үүсвэрээс гадна сэргээгдэх эрчим хүчийг хослуулан ашиглах нь тохиромжтой.

**9.6** Барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг сонгохдоо цахилгаан техникийн стандартын шаардлага хангасан материалыг сонгон хэрэглэх шаардлагатай.

## **10 Гамшиг, галын аюулгүй байдлын шаардлага**

**10.1** Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж (галын автомат систем, ус хангамж г.м)-ийг ашиглалтын байнгын бэлэн байдалд байлгана.

**10.2** Эдэлбэр газар дахь барилга байгууламж болон орон сууц, бусад барилгын хооронд төлөвлөгдсөн галын аюулгүйн зайд байгаа шатамхай хог хаягдлыг тухай бүр нь цэвэрлэнэ.

**10.3** Эдэлбэр газарт амьдарч буй өрх бүр гал гарсан үед ашиглах багаж хэрэгсэлтэй байна (гал унтраагуур, хүрз, хувин, дэгээ, эсгий, цохиур г.м).

**10.4** Нэг айл болон блокчилсон амины орон сууц нь аврах гарцтай, галд тэсвэршилтийн II-оос доошгүй зэрэгтэй байна.

**10.5** Цахилгаан дамжуулалтад хэрэглэгдэх утас ба кабелин тусгаарлалт нь түүнийг сунгах арга ба хүрээлэн байгаа орчны нөхцөлтэй тохирч байх ёстой.

**10.6** Галын аюулгүйн нөхцөлөөр утас ба кабел, мөн түүнчлэн хоолой, хайрцагт угсрахдаа шатдаггүй эсвэл муу шаталттай бүрээс бүхий утас буюу кабел хэрэглэх шаардлагатай.

**10.7** Гал тэсвэршилтийн I, II, III зэрэгтэй цөөн давхар орон сууцны барилгын даацын бус хана болон барилгын хонгил, өрөө тасалгааг хооронд нь зааглаж байгаа хана, хамар ханын гал тэсвэршилтийн хязгаар 0,75 цагаас багагүй байна.

**10.8** Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдрах орон сууцны барилгын гал тэсвэршилтийн зэргийн доод хязгаар II зэрэгтэй байна.

**10.9** Гал тэсвэршилтийн IV зэрэглэлтэй хоёр хүртэл давхар сууцны барилгын даацын үндсэн бүтээцийн гал тэсвэршилтийн хязгаар R30-аас багагүй байна.

**10.10** Залгаж барьсан хоёр ба түүнээс дээш автомашины битүү зогсоолтой тохиолдолд сууцны өрөө тасалгаа нь REI 45-аас багагүй гал тэсвэршилтийн хязгаартай хамар хана, хучилтаар тусгаарласан байна.

**10.11** Сууцны барилгын хийц бүтээц нь гал тархдаггүй байх шаардлагатай.

**10.12** Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй тохиолдолд гал унтраах усны нөөц сав буюу усан санг ашиглах боломжийг зураг төсөлд тусгахыг зөвшөөрнө.

**10.13** Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон тохиолдолд эдэлбэр газрын гадна гал унтраах ус хангамжийн шугам сүлжээг холбогдох нормын шаардлагын дагуу төлөвлөнө.

**10.14** Нэг айлын сууц нь галын аюулын Ф1.4 ангид хамаарагдана. Аль ч барилга байгууламж дотор гал гарах боломжийг харгалзан барилгаас гадагш гарах гарцыг заавал төлөвлөсөн байна.

## **MNS 6877:2020**

**10.15** Зэрэгцүүлэн барьсан сууцны блокуудыг REI 45-аас доошгүй гал тэсвэршилтийн хязгаартай материалаар хийгдсэн хамар ханаар тусгаарлах ба энэ нь галын аюулын анги Г1-ээс багагүй байна.

**10.16** 3 давхар сууцны үндсэн хийц бүтээц нь гал тэсвэршилтийн III зэрэгтэй нийцэж байвал зохино.

**10.17** Давхрын талбайн хэмжээ нь 150 м<sup>2</sup>-аас бага тохиолдолд даацын элементүүдийн гал тэсвэршилтийн хязгаар нь R30-аас, хучилт нь REI 30-аас багагүй байна.

**ТӨГСӨВ.**

## 11 Ном зүй

1. MNS 5611, Орон сууцны барилгад тавих үндсэн шаардлага
2. MNS 5342, Автомашины зогсоол. Ангилал, ерөнхий шаардлага
3. MNS 5973, Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ
4. MNS 6260, Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
5. MNS BS 5906, Барилга доторх хог хаягдлын менежмент – Ашиглалтын дүрэм
6. MNS 5924, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
7. MNS 3239, Барилга доторх ус хангамж, ариутгах татуургын ажлын зураг
8. MNS 6230, Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага
9. MNS 0900, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
10. MNS ISO 9972, Барилгын дулаан хамгаалалт – Барилгын агаар нэвтрүүлэлтийг тодорхойлох – Сэнсээр даралт үүсгэх арга
11. ISO 6946, Building components and building elements – Thermal resistance and thermal transmittance – Calculation method
12. MNS ISO 13790, Барилгын дулаан хамгаалалт-Халаалт ба хөргөлтийн эрчим хүчний тооцоо
13. MNS IEC 529, Хайрцаг самбарын хамгаалалт
14. MNS IEC 38, Стандарт хүчдэл
15. MNS IEC 2980, Цахилгаан эрчим хүчний чанар. Нэр томьёо, тодорхойлолт
16. MNS 6279, Ус хангамж ариун цэврийн байгууламж нэр томьёо, тодорхойлолт-Тайлбар толь
17. DIN EN ISO 10211-28 Thermal bridges in building construction - Calculation of heat flows and surface temperatures - Part 2: Linear thermal bridges
18. БНБД 30-01-04, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм
19. БНБД 31-09-07, Нэг айлын орон сууцны барилгын төлөвлөлт ба угсралт
20. БНБД 31-05-05, Нэг айлын сууц
21. БНБД 31-01-10, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм
22. БНБД 23-04-07, Орон сууц, олон нийтийн барилга, орон сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж
23. БНБД 21-01-02, Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал
24. БНБД 3.01.06-90, Барилгын орчны тохижилтын ажил
25. БНБД 21-05-10, Авто зогсоол
26. БНБД 3.05.06-9, Цахилгаан техникийн ажил
27. БНБД 23-02-08, Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг
28. БНБД 40-02-16, Ус хангамж гадна сүлжээ ба байгууламж
29. БНБД 40-06-16, Дотор сантехникийн систем
30. БНБД 40-05-16, Барилга доторх ус хангамж ба ариутгах татуурга
31. БНБД 40-01-14, Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж
32. БНБД 23-02-09, Барилгын дулаан хамгаалалт
33. БНБД 23-01-09, Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд
34. БД 30-101-05, Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт, зохион байгуулалт, барилгажилт
35. БД 31-101-04, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрэм
36. БД 30-10-11, Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх
37. БД 43-101-03, Цахилгаан байгууламжийн дүрэм

## **MNS 6877:2020**

- 38.БД 43-103-08, Барилга байгууламжийн аянгын хамгаалалтын зураг төсөл зохиох заавар
- 39.БД 43-102-07, Орон сууц, олон нийтийн байгууллагын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах
- 40.БД 30-10-11, Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх
- 41.ЭХД1-13-01-2006, Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03-д оруулсан өөрчлөлтүүд II бүлэг 2.4 зүйл 1кВ хүртэлх хүчдэлтэй ЦДАШ
- 42.БД 81-101-01, Барилгын ажлын тоо хэмжээ бодох аргачилсан заавар